



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/398

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн “Хичээлийн жилийн бүтцийг шинэчлэн батлах тухай” А/338 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” А/350 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан “Дунд ангийн сургалтын төлөвлөгөө”-ний VI ангийн долоо хоногийн нийт ачаалал “31” гэснийг “29” гэж, өдрийн дундаж ачаалал “6.2” гэснийг “5.8” гэж өөрчилсүгэй.

2. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” А/350 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан “Дунд ангийн сургалтын төлөвлөгөө”-ний “Багш зохицуулах цаг VI анги: 66, VII анги: 66, VIII анги: 66, IX анги: 66” гэснийг тус тус хассугай.

3. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сургалтын төлөвлөгөөг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

4. Энэ тушаалыг 2023-2024 оны хичээлийн жилээс өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуульд хэрэгжүүлсүгэй.

5. Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, багш нарт тушаалын хэрэгжилттэй холбоотой удирдлага, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир), аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн Боловсролын газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

6. Энэ тушаал гарсантай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” А/350 дугаар тушаалын гуравдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

14231 1545

Боловсрол, шинжлэх ухааны сайдын  
2023 оны 09 дүгээр сарын 26 ны өдрийн  
1/398 дугаар тушаалын хавсралт

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН АХЛАХ АНГИЙН  
СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хичээл			Хичээлийн цаг			Нийт цаг	
			X анги	XI анги	XII анги		
Заавал судлах	1	Монгол хэл	34	34	34	102	
	2	Үндэсний бичиг	68	68	68	204	
	3	Уран зохиол	34	34	34	102	
	4	Иргэний ёс зүйн боловсрол	68	68	68	204	
	5	Математик	102	102	102	306	
	6	Мэдээллийн технологи	34	34	34	102	
	7	Биологи	68	68		136	
	8	Физик	68	68		136	
	9	Хими	68	68		136	
	10	Монголын түүх	34	34		68	
	11	Нийгэм судлал	68	68		136	
	12	Газар зүй	68	68		136	
	13	Англи хэл/Орос хэл	102	102	102	306	
	14	Биеийн тамир	68	68	68	204	
	15	Эрүүл мэнд	34	34	34	102	
	16	Дизайн/зураг зүй, технологи	68	68	68	204	
Сонгон судлах	1	Хэл	Монгол хэл, бичиг	204	204	612	1020
	2		Уран зохиол				
	3		Англи хэл				
	4		Орос хэл				
	5	Математик	Математик				
	6	Байгалийн ухаан	Биологи				
	7		Физик				
	8		Хими				
	9	Нийгмийн ухаан	Нийгэм судлал				
	10		Түүх				
	11		Газар зүй				
	12		Бизнес судлал				
	13	Дизайн технологи	Дизайн, зураг зүй				
	14		Техник технологи				
	15		Мэдээллийн технологи				
Заавал судлах цаг			986	986	612	2584	
Сонгон судлах цаг			204	204	612	1020	
Жилийн нийт цаг			1190	1190	1224	3604	
Долоо хоногийн нийт ачаалал			35.0	35.0	36.0		
Өдрийн дундаж ачаалал			7.0	7.0	7.2		
Багш зохицуулах цаг						102	

1. X-XII анги 37 долоо хоног хичээллэнэ. Ээлжит хичээлийг 40 эсхүл 80 минутаар зохион байгуулж болно.
2. Суралцагч X ангид 4 хичээл, XI, XII анги тус бүрд 3 хичээлийг сонгон судална. Сонгон судлах хичээл тус бүрийг X ангид 2 долоо хоногт 3 цагаар, XI ангид долоо хоногт 2 цагаар, XII ангид долоо хоногт 6 цагаар тус тус судална.
3. Заавал судлах гадаад хэлний хичээлээр англи, орос хэлний аль нэгийг судална.

4. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 22.3-т заасны дагуу сонгон судлах хичээлийг холимог бүлгээр зохион байгуулж болно.
5. "Иргэний ёс зүйн боловсрол" хичээлийг нийгмийн ухааны багш заана.
6. Багш зохицуулах цагийг хичээлийн цагт тооцно.
7. Хичээлийн жилийн бүтцийн 18, 19 дэх долоо хоногт заавал болон сонгон судлах хичээлийн агуулгыг бататгах, сурлагын хоцрогдол нөхөх, төсөлт ажил зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг, 41 дэх долоо хоногт анги дэвших болон төгсөлтийн үнэлгээг тус тус зохион байгуулна.

---o0o---